



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/113

Есөнбулаг

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.3, 28.1.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайд Говь-Алтай аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.3 дахь хэсэгт тусгагдсан тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх зорилт, аймгийн Засаг даргын 2023 оны А/113 дугаар захирамжаар баталсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутагт зохион байгуулагдах томоохон арга хэмжээнүүд болон бусад үед ард иргэдийн аюулгүй байдлыг хангах, орчны хяналтыг хийхэд зөөврийн теле хяналтын систем нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсугай.

2. Зөөврийн теле хяналтын систем нэвтрүүлэхэд 6,783,500 (зургаан сая долоон зуун наян гурван мянга таван зуу) төгрөг, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2,000,000 (хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Золжаргал), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР